




**СҮХБААТАР АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН
АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ**

22000 Баруун-Урт, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70510051

БАТЛАВ.



2022.02.16 № 01

Шалгалт хийх тухай

Нэг. Нийтлэг үндэслэл

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д "Яам, агентлаг болон засгийн газраас байгуулдаг төрийн захиргааны байгууллага нь харьяа байгууллага, аж ахуй нэгжийн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийж арга хэмжээ авна", "Дотоод аудитын албаны дүрэм" зэргийг тус тус үндэслэн санхүүгийн хяналт шалгалт хийнэ.

Хоёр. Шалгалтын зорилго

Монгол улсын Сангийн сайдын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01 тоот удирдамжийн дагуу бүх төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн болон орон нутгийн өмчит газрын 2016-2021 онуудад төрийн албанаас үндэслэлгүйгээр халагдсан нь шүүх болон бусад эрх бүхий холбогдох байгууллагын шийдвэрээр тогтоогдсон, мөн шийдвэрийн дагуу холбогдох этгээдэд төсвөөс хөрөнгө зарцуулсан зарцуулалтад Монгол улсын Төсвийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд шалгалт хийж, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, засаж залруулахад чиглэгдэнэ.

Гурав. Шалгалтын хамрах хүрээ, бүрэлдэхүүн, хугацаа

Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төсөвт газрын болон, төрийн өмчит үйлдвэрийн газрын 2016 оноос 2021 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор Т.Цэрэгбаяр ахалж, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор Д.Оюунсүрэн, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор Б.Чулуунбат, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор Г.Сансар, ахлах дотоод аудитор Х.Хүрэлцэцэг, дотоод аудитор Л.Цэгмэд, Б.Цэрэнпагма нарын бүрэлдэхүүнтэй 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс ажлын 15 хоногт хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Шалгалтад хамрагдах асуудлууд

4.1. 2016-2021 онуудад төрийн албанаас үндэслэлгүй халагдсан нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон эсэх

4.2. Эргэн албан тушаалдаа томилогдсон эсэх, хохирлын хэмжээ

4.3. Албан тушаалтанд төсвөөс олгосон нөхөн олговор

4.4. Холбогдох хуулийн дагуу буруутай албан тушаалтнаар төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлсэн байдал

4.5. Тухайн асуудлаар өмнө хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил төлбөр, түүний барагдуулалт

Тав. Үүрэг хариуцлага

5.1 Хяналт шалгалтад хамрагдаж буй байгууллага

5.1.1 Шаардлагатай тайлан мэдээ, санхүүгийн баримт материалыг ажлын хэсэгт шаардсан хугацаанд саадгүй гаргаж өгөх

5.1.2 Шалгалтын явцад холбогдох программ хангамжид нэвтрэн шалгалт хийх нөхцөл бололцоогоор хангах

5.1.3 Шалгалтын танилцуулгын төсөлтэй танилцаж санал, тайлбар өгөх

5.1.4 Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах

5.1.5 Дотоод аудитын хорооноос гарсан шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэх

5.2 Хяналт шалгалт хийх ажлын хэсэг

5.2.1 Хяналт шалгалтыг явуулахдаа удирдамжийн хүрээнд ажиллах

5.2.2 Шалгалтын ажлын явцад хамрагдаж буй байгууллага, газрын талаарх мэдээллийн нууцлалыг хадгалах

5.2.3 Шалгалтыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу чанартай, бие даасан байдалтай гүйцэтгэх


Зургаа. Шалгалтын дүнг тайлагнах

6.1 Шалгалтын дүнг тухайн байгууллагын удирдлагад, шаардлагатай бол хамт олонд танилцуулж, даргын зөвлөлд ажлын 5 хоногт багтаан хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах.

6.2 Дотоод аудитын хорооноос гарсан шийдвэр, зөвлөмжийг холбогдох байгууллага, газруудад хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ, ДОТООД АУДИТОР



Т.ЦЭРЭГБАЯР